



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/18/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2022 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Х.Алтанчимэг Утас: 90060105 Цахим хаяг: Altanchimegkh@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.12 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭСЯ	Элчин сайдын яам

1.Аудитын санал дүгнэлт

 АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 65130 Цэцэрлэг, Архангай аймаг Утас/Факс: 976-70333141 И-мэйл: arkhangai@audit.gov.mn	<p>АРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА Д.ЭРДЭНЭБААТАР ТАНАА</p>
2022.02.25 № 58	
танай _____ -ны № _____ -т	
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	
Зөрчилгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Архангай аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p> <p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.</p>	
Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага	
<p>Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.</p> <p>Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.</p> <p>Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.</p>	
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	 Т.БАЙГАЛМАА
	

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	645,824,084.24	812,197,240.47
35	БАРАА МАТЕРИАЛ	645,824,084.24	812,197,240.47
35100	Түүхий эд материал	354,095,367.97	388,469,144.72
35110	Тусгай зориулалттай материал	348,953,867.97	364,667,644.72
35130	Эм боох материал	5,141,500.00	23,801,500.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	172,582,515.40	229,145,685.40
35400	Хангамжийн материал	118,546,200.87	189,067,517.75
35410	Бичиг хэргийн материал	4,587,540.00	4,517,320.00
35420	Аж ахуйн материал	71,792,514.75	71,792,514.75
35430	Сэлбэг хэрэгсэл	9,331,000.00	9,621,000.00
35440	Түлш, шатах тослох материал	10,657,024.12	1,900,331.00
35450	Барилгын засварын материал	1,608,470.00	67,997,500.00
35470	Бусад хангамжийн материал	20,569,652.00	33,238,852.00
35500	Биологийн хөрөнгө	0.00	4,914,892.60
35600	Мал амьтад	600,000.00	600,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,065,941,535.96	6,217,641,482.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,065,941,535.96	6,217,641,482.86
39200	Биет хөрөнгө	4,893,292,285.96	6,045,123,482.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,737,013,842.00	3,737,013,842.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-254,028,230.00	-302,331,602.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,976,194,890.90	3,185,306,490.90
39204	Хуримтлагдсан элэгдэл	-640,902,062.23	-748,876,439.91
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,997,816.75	78,036,698.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,165,245.66	-26,531,518.22
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	471,665,719.71	456,011,654.59
39212	Хуримтлагдсан элэгдэл	-433,484,445.51	-373,505,642.48
39214	Бусад үндсэн хөрөнгө	58,622,003.85	98,622,003.85
39215	Хуримтлагдсан элэгдэл	-58,622,003.85	-58,622,003.85
39300	Биет бус хөрөнгө	172,649,250.00	172,518,000.00
39301	Програм хангамж	1,155,000.00	1,155,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,023,750.00	-1,155,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	172,518,000.00	172,518,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,711,765,620.20	7,029,838,723.33
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,711,765,620.20	7,029,838,723.33
51	Засгийн газрын хувь оролцоо	5,711,765,620.20	7,029,838,723.33
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	652,379,989.88	652,379,989.88
51200	Хуримтлагдсан үр дүн	4,450,275,215.22	5,768,348,318.35
51210	Өмнөх үеийн үр дүн	3,903,607,024.43	4,450,275,215.22
51220	Тайлант үеийн үр дүн	546,668,190.79	1,318,073,103.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	609,110,415.10	609,110,415.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,711,765,620.20	7,029,838,723.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,519,979,498.00	3,574,672,167.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	784,840,208.00	1,596,009,104.60
120	Нийтлэг татварын бус орлого	784,840,208.00	1,596,009,104.60
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	706,724,680.00	1,321,635,770.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	78,115,528.00	274,373,334.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,735,139,290.00	1,978,663,063.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,463,942,500.00	1,513,476,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,463,942,500.00	1,513,476,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	271,196,790.00	465,186,763.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	44,257,250.00	59,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,790,800.00	261,135,763.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	161,148,740.00	145,051,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,947,311,307.21	2,256,599,064.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,947,311,307.21	2,256,599,064.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,871,611,192.64	2,252,969,064.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,120,042,000.54	1,194,635,500.00
210101	Үндсэн цалин	712,114,600.00	695,144,100.00
210102	Нэмэгдэл	380,256,900.54	473,366,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,670,500.00	26,124,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,846,336.37	32,471,500.00
210201	Тэтгэврийн даатгал	6,633,363.19	20,154,899.00
210202	Тэтгэмжийн даатгал	940,900.18	8,658,301.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	503,819.00	526,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	125,954.00	131,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,642,300.00	3,000,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,798,929.06	141,948,300.33
210301	Гэрэл, цахилгаан	6,496,000.00	8,775,269.45
210302	Түлш, халаалт	124,790,584.84	128,205,030.88
210303	Цэвэр, бохир ус	4,512,344.22	4,968,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	139,784,073.40	122,455,613.04
210401	Бичиг хэрэг	10,074,891.00	19,856,167.00
210402	Тээвэр, шатахуун	80,948,050.00	91,267,941.24
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,034,059.00	7,240,281.55
210408	Бараа материал акталсны зардал	46,727,073.40	4,091,223.25
2105	Нормативт зардал	67,144,320.00	207,415,623.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,894,880.00	48,794,350.00
210502	Хоол, хүнс	58,116,940.00	157,201,273.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	132,500.00	1,420,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,512,585.00	16,093,020.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,363,225.00	6,813,400.00
210604	Урсгал засвар	4,808,860.00	9,279,620.00
2107	Томилолт, зочны зардал	73,203,700.00	83,043,200.00
210702	Дотоод албан томилолт	73,203,700.00	83,043,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,454,320.00	7,803,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1,798,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,200,900.00	2,175,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	848,300.00	1,796,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	616,000.00	178,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	410,500.00	1,109,000.00
210807	Газрын төлбөр	403,620.00	745,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	270,824,928.27	447,103,208.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,712,200.00	273,629,025.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,292,250.00	3,538,360.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	252,820,478.27	169,935,823.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,700,114.57	3,630,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,527,500.00	3,630,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	58,527,500.00	3,630,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	572,668,190.79	1,318,073,103.13
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	546,668,190.79	1,318,073,103.13

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	652,379,989.88	609,110,415.10	4,450,275,215.22	5,711,765,620.20
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	652,379,989.88	609,110,415.10	4,450,275,215.22	5,711,765,620.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	652,379,989.88	609,110,415.10	4,450,275,215.22	5,711,765,620.20
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,318,073,103.13	1,318,073,103.13
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	652,379,989.88	609,110,415.10	5,768,348,318.35	7,029,838,723.33

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,735,139,290.00	1,978,663,063.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,735,139,290.00	1,978,663,063.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,463,942,500.00	1,513,476,300.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,463,942,500.00	1,513,476,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	271,196,790.00	465,186,763.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	44,257,250.00	59,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,790,800.00	261,135,763.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	161,148,740.00	145,051,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,692,838,990.54	1,978,663,063.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,692,838,990.54	1,978,663,063.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,614,823,875.97	1,975,033,063.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,120,042,000.54	1,194,635,500.00
210101	Үндсэн цалин	712,114,600.00	695,144,100.00
210102	Нэмэгдэл	380,256,900.54	473,366,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,670,500.00	26,124,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,846,336.37	32,471,500.00
210201	Тэтгэврийн даатгал	6,633,363.19	20,154,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	940,900.18	8,658,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	503,819.00	526,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	125,954.00	131,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,642,300.00	3,000,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,048,929.06	140,178,600.00
210301	Гэрэл, цахилгаан	6,496,000.00	9,960,597.00
210302	Түлш, халаалт	127,040,584.84	125,250,003.00
210303	Цэвэр, бохир ус	4,512,344.22	4,968,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	98,558,390.00	89,743,460.00
210401	Бичиг хэрэг	8,524,700.00	18,421,760.00
210402	Тээвэр, шатахуун	85,768,340.00	61,178,440.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,265,350.00	10,143,260.00
2105	Нормативт зардал	63,932,900.00	202,933,163.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,352,500.00	45,414,350.00
210502	Хоол, хүнс	50,373,500.00	156,098,813.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	206,900.00	1,420,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,230,200.00	65,116,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	49,430,900.00	5,487,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,283,000.00	0.00
210604	Урсгал засвар	9,516,300.00	59,629,000.00
2107	Томилолт, зочны зардал	73,203,700.00	83,043,200.00
210702	Дотоод албан томилолт	73,203,700.00	83,043,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,454,320.00	9,847,600.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	975,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,175,900.00	2,175,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	848,300.00	1,796,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	616,000.00	178,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	435,500.00	1,109,000.00
210807	Газрын төлбөр	403,620.00	745,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,507,100.00	157,063,640.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,880,800.00	152,002,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,626,300.00	5,061,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,015,114.57	3,630,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,842,500.00	3,630,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,842,500.00	3,630,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,172,614.57	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,172,614.57	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	42,300,299.46	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	42,300,300.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,300,300.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	42,300,300.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,300,300.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-42,300,300.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-0.54	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.54	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,513,476,300.00	1,513,476,300.00	0.00	100
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,513,476,300.00	1,513,476,300.00	0.00	100
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,509,846,300.00	1,509,846,300.00	0.00	100
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,194,635,500.00	1,194,635,500.00	0.00	100
210101	Үндсэн цалин	695,144,100.00	695,144,100.00	0.00	100
210102	Нэмэгдэл	473,366,500.00	473,366,500.00	0.00	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,124,900.00	26,124,900.00	0.00	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,471,500.00	32,471,500.00	0.00	100

210201	Тэтгэврийн даатгал	20,154,900.00	20,154,900.00	0.00	100
210202	Тэтгэмжийн даатгал	8,658,300.00	8,658,300.00	0.00	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	526,700.00	526,700.00	0.00	100
210204	Ажилгүйдлийн даатгал	131,600.00	131,600.00	0.00	100
210205	Эрүүл мэндийн даатгал	3,000,000.00	3,000,000.00	0.00	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,908,600.00	136,908,600.00	0.00	100
210301	Гэрэл, цахилгаан	9,296,000.00	9,960,597.00	664,597.00	107.1492793
210302	Түлш, халаалт	122,644,600.00	121,980,003.00	664,597.00	99.45811149
210303	Цэвэр, бохир ус	4,968,000.00	4,968,000.00	0.00	100
2104	Хангамж, бараа материалын зардал	23,483,400.00	23,483,400.00	0.00	100
210401	Бичиг хэрэг	2,746,200.00	2,746,200.00	0.00	100
210402	Тээвэр, шатахуун	18,449,400.00	18,449,400.00	0.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,287,800.00	2,287,800.00	0.00	100
2105	Нормативт зардал	45,658,500.00	45,658,500.00	0.00	100
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	346,500.00	346,500.00	0.00	100
210502	Хоол, хүнс	45,312,000.00	45,312,000.00	0.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,445,000.00	60,445,000.00	0.00	100
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,815,000.00	1,815,000.00	0.00	100
210604	Урсгал засвар	58,630,000.00	58,630,000.00	0.00	100
2107	Томилолт, зочны зардал	1,335,200.00	1,335,200.00	0.00	100
210702	Дотоод албан томилолт	1,335,200.00	1,335,200.00	0.00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,847,600.00	9,847,600.00	0.00	100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,842,600.00	3,842,600.00	0.00	100
210803	Даатгалын үйлчилгээ	2,175,900.00	2,175,900.00	0.00	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,796,300.00	1,796,300.00	0.00	100
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	178,200.00	178,200.00	0.00	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,109,000.00	1,109,000.00	0.00	100
210807	Газрын төлбөр	745,600.00	745,600.00	0.00	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,061,000.00	5,061,000.00	0.00	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,061,000.00	5,061,000.00	0.00	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,630,000.00	3,630,000.00	0.00	100

2132	Бусад урсгал шилжүүлэг	3,630,000.00	3,630,000.00	0.00	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,630,000.00	3,630,000.00	0.00	100
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,513,476,300.00	1,513,476,300.00	0.00	100
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,513,476,300.00	1,513,476,300.00	0.00	100
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,513,476,300.00	1,513,476,300.00	0.00	100
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	85.00	85.00	0.00	100
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	76.00	76.00	0.00	100
650010	Гэрээт ажилтан	9.00	9.00	0.00	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	465,186,763.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	465,186,763.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	465,186,763.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,270,000.00
210302	Түлш, халаалт	3,270,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,260,060.00
210401	Бичиг хэрэг	15,675,560.00
210402	Тээвэр, шатахуун	42,729,040.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,855,460.00
2105	Нормативт зардал	157,274,663.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,067,850.00
210502	Хоол, хүнс	110,786,813.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,420,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,671,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,672,400.00
210604	Урсгал засвар	999,000.00
2107	Томилолт, зочны зардал	81,708,000.00
210702	Дотоод албан томилолт	81,708,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	152,002,640.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	152,002,640.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	406,186,763.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	406,186,763.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	261,135,763.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	145,051,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Архангай аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Онцгой байдлын газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 8 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Онцгой байдлын газар нь 2021 онд дараах зорилтыг тавин ажилласан байна. Үүнд:

- Онцгой байдлын албаны техник багаж тоног төхөөрөмж, хувцас хэрэгслийн чанар ашиглалтыг сайжруулах
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг цахимжуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Гамшгаас хамгаалах тухай хууль
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын хяналтын багийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Онцгой байдлын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 1,506.0 сая төгрөгөөс 1%-иар буюу 15.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 %-иар буюу 10.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 1,318.1 сая төгрөгөөр буюу 18.7 хувиар өссөн байна. Оны эхний үлдэгдлээс материаллаг өөрчлөлт гарсан данс нь үндсэн хөрөнгө бараа материалын данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
1	2	3	4=3-2	
Бараа материал	645.8	812.2	166.4	20.5
Үндсэн хөрөнгө	5,065.9	6,217.6	1,151.7	18.5
Нийт хөрөнгө	5,711.7	7,029.8	1,318.1	18.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,711.7	7,029.8	1,318.1	18.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,711.7	7,029.8	1,318.1	18.7

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Бараа материал эхний үлдэгдлээс 166.4 сая төгрөг буюу 20.5 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын данс нь 645.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 435.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 268.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 812.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 1,151.7 сая төгрөг буюу 18.5 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 5,065.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд 1,322.7 сая төгрөгийн хөрөнгийн хандив тусламжаар хөрөнгө нэмэгдэж, тайлант хугацаанд

байгуулсан 171.0 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурч 6,217.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой бөгөөд тайлант хугацаанд 1,318.1 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,519.8	3,574.6	1,054.8
2	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	784.8	1,596.0	811.2
3	Төрийн болон орон нутгийн өмчит этгээдээс авсан хандив		59.0	59.0
4	ЗГНХ, ЗДНХ-түүнтэй адилтгах хөрөнгө	110.0	261.2	151.2
5	Дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан хөрөнгө	161.1	145.0	(16.1)
6	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,463.9	1,513.4	49.5
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,973.3	2,256.6	283.3
8	Бараа, ажил үйлчилгээний зардал	1,871.6	2,253.0	381.4
9	Урсгал шилжүүлэг	75.7	3.6	(72.1)
10	Хөрөнгийн зардал	26.0		(26.0)
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	546.5	1,318.0	771.5

Архангай аймгийн Онцгой байдлын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 1,054.8 сая төгрөг буюу 41.8 хувиар урсгал үйл ажиллагааны зардал 283.3 сая төгрөгөөр тус тус өссөн нь хандив тусламжаар ирсэн хөрөнгө болон ковид-19 цар тахалтай холбоотой Аймгийн онцгой комиссоос ирсэн санхүүжилттэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,600.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 94.0 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 1,513.4 сая төгрөгөөр хянаж баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 1,513.4 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүжилтээ бүрэн авч зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар сая төгрөгийн орлого төвлөрч дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар Онцгой байдлын ерөнхий газраас гамшиг ослын томилолт 84.7 сая төгрөг, Хангай-21 дадлага сургуулилтад 7.3 сая төгрөг, ЗГ-ын 75-р тогтоолын дагуу 50.0 сая төгрөг, ахмадын сангийн санхүүжилт 3.0 сая төгрөг нийт 145.0 ирснийг газрын даргын тушаалаар зарцуулсан байна.
- Аймгийн засаг даргын нийт 9 удаагийн захирамжаар ковид-19 цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд зориулан 261.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.
- Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтын дагуу иргэн, аж ахуйн нэгжүүдээс Аймгийн онцгой комисст ковид 19 цар тахалтай холбоотой 59.0 сая төгрөгийн хандивын орлого төвлөрснийг Аймгийн онцгой комиссын даргын шийдвэрээр тусгаарлах байрны хоол, хүнс, аж ахуйн материал болон шатахууны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. Тайлант жилд ОБЕГ-ын даргын 2021 оны 06 сарын 06-ны А/185 тоот тушаалаар Америкийн нэгдсэн улсын ЭСЯ, Иргэн цэргийн харилцааны дэмжлэгийн багтай хамтран “Хангай-21” гамшигийн хор уршгийг арилгах дадлага сургуулийг Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт 2021 оны 0 сарын 12-ноос 9 сарын 24-ны өдрүүдэд зохион байгуулсан байна. Тус арга хэмжээнд 113 албан хаагчид оролцож, 30.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Тус арга хэмжээд зориулан ОБЕГ-аас 7.3 сая төгрөг, Аймгийн засаг даргын нөөц сангаас 55.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.
2. Тариат суманд эрэн хайх, аврах бүлэг байгуулахтай холбогдуулан сум дундын эмнэлгийн барилгыг Онцгой байдлын ерөнхий газар бүртгэлдээ тусгаж 50.0 сая төгрөгөөр Мегаватт Хурд ХХК-иар их засварын ажлыг гүйцэтгүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 10 үндсэн зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 1513.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

Онцгой байдлын газар нь тусгай чиг үүргийн байгууллага тул төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ хамааралгүй байна.

Харин бусад судалгааны хувьд дараах байдалтай байна.

1. Автомашин ашиглалтын хувьд: Тус байгууллагад үндсэн үйл ажиллагаанд зориулсан 3,185.3 сая төгрөгийн 24 автомашинтай бөгөөд жилийн шатахууны 39.8 сая төгрөг, сэлбэг хэрэгслийн зардалд 1.8 сая төгрөгийг тус тус зарцуулж үндсэн орон тооны 24 жолоочтой байна.
2. Тайлант жилд ковид-19 цар тахал гарсантай холбогдуулан аймгийн онцгой комисст иргэн ААНБ-аас олгосон хандив урамшууллыг аймгийн Онцгой байдлын газрын нэмэлт санхүүжилтийн болон бараа материалын дансаар дамжуулан онцгой комиссын даргын шийдвэрээр зарцуулсан байна. Тайлант жилд 59.0 сая төгрөгийн мөнгөн, 42510 нэр

төрлийн мөнгөн бус хандив цугларсныг Онцгой комиссын захирамжаар зарцуулсан байна.

3. Хэвлэл мэдээллийн байгууллагатай жилийн турш ажил үйлчилгээ авах гэрээ байгуулан 1.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Архангай аймгийн Онцгой байдлын газар нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 169 мэдээллээс 137 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна. Харин 32 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан 42.0 сая төгрөгийн төсөвтэй хоол хүнсний зардалд үнэлгээний хороо байгуулж, тендер ХАА-г зохион байгуулаагүй шууд худалдан авалтыг хийсэн нь ТБОНӨБАҮАТХ-ын 45.1.Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ авах тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, тендер худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн 4.1.3 дахь заалт, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Архангай аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй байна.

3.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналт, үндсэн хөрөнгийн элэгдлийн хугацаатай холбоотой зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж биелэлтийг Онцгой байдлын газрын даргын 2021.06.23-ны 188 тоот албан бичгээр хангуулсан байна. Аудитаас хүргүүлсэн шийдвэрийн дагуу элэгдлээ бүрэн нөхсөн 73.2 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хассан байна.м

3.12 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тариат сум дахь эрэн хайх, аврах бүлгийн бүлгийн үйл ажиллагаанд зарцуулсан санхүүжилтийг шалгах

-----oOo-----

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 45.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, тендер худалдан авалт зохион байгуулах албан шаардлага, хоолны норм нормативыг, тооцох, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

Аудитаас илэрсэн асуудал нь материаллаг шинжтэй бус тул Архангай аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд “Зөрчилгүй” дүгнэлт хүргүүлээ.

4.1 Зөвлөмж

Хоолны зардлыг анхан шатны баримтаас түүвэрлэн шалгахад норм тооцдоггүй, тогоочийн захиалгын хуудсыг бүрэн бөглөдөггүй, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт материалыг бүрэн хөтлөхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.1 " 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх", ОБГ-ын даргын 2019 оны 08 сарын 23-ны А/251 тоот тушаалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Иймд ОБГ-ын даргын дээрх тушаалын дагуу хоолны норм тооцохдоо ээлжээр ажилладаг албан хаагчийн хүнсний зардлыг өдөрт 8.0 мянган төгрөгөөр тооцож хэвших, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Онцгой байдлын газар	1								1	
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Онцгой байдлын газар	2	45.2					1	45.2	1	
НИЙТ ДҮН		3	45.2					1	45.2	1	